



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 1122

Шивээговь сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 48.2.3, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар “Сумын 2025 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2025 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Гэр хорооллын гадна цэвэр ус, гадна бохир усны шугамд холбох ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Б.Болд-Эрдэнэ

(Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга)

Гишүүд:

Б.Доржханд

(Илчлэг Шивээ ОНӨААТҮГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Базаррагчаа

(Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн дарга)

Хөндлөнгийн төлөөлөл:

Н.Энхтайван

(Сумын 1 дүгээр багийн иргэн)

Нарийн бичгийн дарга:

Д.Баттуул

(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн шалгарсан гүйцэтгэгчийн гэрээний биелэлтэд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Шивээговь сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА